



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 9509

Номгон

Г
Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн
боловсрол, цэцэрлэгийн багш, удирдах
ажилтныг сонгон шалгаруулах
журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ийн "а" дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын газраас ирүүлсэн саналын дагуу Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсрол, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, удирдах ажилтныг сонгон шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

2.Сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй, шударга зохион байгуулж ажиллахыг Боловсролын газар (даргын албан үүргийг тор орлон гүйцэтгэгч Ц.Энхтөр)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Наранбаяр)-т даалгасугай.


ДАРГА



МӨНХСАЙХАН

601210175

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар
сарын 16-ны өдрийн А/509 дүгээр
зажирамжийн хэвсрэлт



**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, НАСАН ТУРШИЙН
БОЛОВСРОЛ, ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ, УДИРДАХ
АЖИЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ерөнхий боловсролын сургуулийн багш, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, сэтгэл зүйч, Насан туршийн боловсролын төвийн менежер, багш, цэцэрлэгийн багш, арга зүйч, туслах багшийн албан тушаалд ажиллах иргэдийг сонгон шалгаруулах, багшийн мэргэжлийн ур чадварт тавих нийтлэг шаардлагын дагуу боловсролын байгууллагыг чадварлаг боловсон хүчнээр хангах аулгы зохион байгуулахад зохион байгуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Ерөнхий боловсролын сургуулийн багш, сургалтын менежер, Насан туршийн боловсролын төвийн менежер багш, нийгмийн ажилтан, багш, цэцэрлэгийн арга зүйч, багшийн сул ажлын байранд ажиллах багшийг аймгийн хэмжээнд нэгдсэн байдлаар сонгон шалгаруулахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

Хоёр. Баримтлах зарчим

2.1. Сонгон шалгаруулалтыг нээлттэй, шударга, ил тод явуулна

Гурав. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

3.1. Сургууль, цэцэрлэг нь үндсэн ба түр хугацаагаар ажиллах сул орон тооны мэдээллийг мэргэжил тус бүрээр гаргаж, жил бүрийн 8 дугаар сарын 10-ны дотор Боловсролын газарт албан бичгээр ирүүлнэ. Хичээлийн жилийн дундуур сул орон тоо гарсан тохиолдолд ажлын 5 өдөрт багтааж мэдэгдсэн байна.

3.2. Сонгон шалгаруулалтыг хичээлийн шинэ жилийн өмнө нэг удаа зохион байгуулна. Зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд тухайн үед нь түргэн шуурхай зохион байгуулна.

3.3. Боловсролын газар нь сул ажлын байрны мэдээлэл, сонгон шалгаруулалт явуулах хугацаа, товыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

3.4. Сонгон шалгаруулалтыг Боловсролын газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулах бөгөөд ажлын хэсэгт Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтсээс төлөөлөл заавал

оруулна.

3.5. Сонгон шалгаруулах сэдэв тестийг Боловсролын газар болон мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор боловсруулж, нууцлалыг хариуцана.

3.6. Шалгаруулалтыг онлайнаар зохион байгуулж болно. Энэ тохиолдолд тестийг програмд оруулж, компьютер бусад тоног төхөөрөмжийг бэлдсэн байна.

3.7. Сонгон шалгаруулалтад дараах агуулгын хүрээнд зохион байгуулна.

а/Баримт бичгийн шалгаруулалт (Төрийн албан хаагчийн анкет, зураг, төгссөн сургуулийн диплом, багшлах эрхийн үнэмлэх, өргөдөл, ажиллаж байсан албан газрын тодорхойлолт гэх мэт)

б/Мэргэшлийн чадварын шалгалт

в/Мэдээлэл харилцааны технологи ашиглах чадвар зэргээр шалгалтыг тус тус авна. Шаардлагатай гэж үзвэл хөтөлбөр боловсруулах, хичээл заалгах зэргээр багшлах ур чадварт үнэлгээ өгч болно.

3.8. Баримт бичгийн шалгалтад тэнцсэн шалгуулагч мэргэшлийн чадварын шалгалтад 60 хувь ба түүнээс дээш үнэлгээ авч дараагийн шатны шалгалтыг өгөх эрх үүснэ. Дараагийн шатны шалгалт бүрд авах онооны 60-аас доошгүй хувийг авсан тохиолдолд "хангалттай" гэж үзэж шалгалтын нийлбэр онооны дүнгээр жагсаан ил тод мэдээлнэ.

3.9. Сонгон шалгаруулалтад орж, хангалттай үнэлгээ авсан иргэдийг Боловсролын газар хариуцан нөөцөд бүртгэх бөгөөд 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

3.10. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч нь нөөцөд бүртгэгдсэн иргэддээс сул ажлын байрандаа хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилд авна. Сургалтын менежер, арга зүйчийн ажлын байранд багшаар тасралтгүй 5-аас дээш жил ажилласан багшийг нэр дэвшүүлж Боловсролын газартай зөвшилцөн томилно.

3.11. Нөөцөд байгаа багш нараас хамгийн эхэнд байгаа хүн сул ажлын байранд ажиллаагүй тохиолдолд захирал, эрхлэгч нь Боловсрол, соёл урлагийн газартай зөвшилцөн дараагийн хүнийг сонгоно. Хэрэв нөөцөд хүн байхгүй бол сонгон шалгаруулалт дахин явуулна.

Дөрөв. Журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

4.1. Сонгон шалгаруулалтад "Хангалттай" үнэлгээ аваагүй иргэнийг ажиллуулсан тохиолдолд уг иргэнийг ажлаас чөлөөлөх ба үүнтэй холбоотой гарсан хохирлыг захирал, эрхлэгчээр нөхөн төлүүлнэ.

4.2. Сэдэв зохиогч нь сэдвийн нууцлалыг чандлан хадгалах бөгөөд аливаа

сэдвийн нууцыг задруулбал төрийн албан хаагчийн ёс зүйн ноцтой зөрчил гаргасанд тооцож, үүрэгт ажлаас нь чөлөөлөх хүртэл хариуцлагын шийтгэл ногдуулна.

4.3.Сонгон шалгаруулалттай холбоотой гарсан гомдлыг гурав хоногийн дотор бичгээр авч 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

-----oO-----